



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/10/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	4
2. Аудитын тайлан	6
2.1. Оршил.....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.3 Авлага.....	9
2.8.6 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	10
2.8.8 Өр төлбөр	11
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	29
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**ӨРГӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ж.СҮХБААТАР ТАНАА**

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.03.25 № 1-6/361

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ж.Сүхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05-аас 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг гүйцэтгэв.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 5/66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 5088.5 сая төгрөгийн 1 хувь буюу 50.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 5027.1 сая төгрөгийн 1 хувь буюу 50.3 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатны материаллаг түвшнийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, тусгайн сангийн 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллага 2 санхүүгийн тайлантад хамрагдаж, 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, 2 санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Засаг даргын тамгын газар “Зөрчилгүй” дүгнэлтүүдийг өгсөн байна.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 319.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 259.4 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 3.6 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 3.3 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 53.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүлээ. Аудитаар өгсөн зөвлөмжийн 53.1 сая төгрөгийн 4 зөвлөмж нь шинж чанарын хувьд материаллаг бус зөрчил тул зөрчлийн дүнгээс хасч материаллаг байдлын түвшинг тооцлоо.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 259.4 сая төгрөгийн залруулга хийлээ.

- Ерөнхий боловсролын сургууль бохирын шугам засварын 19.0 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогод тусгаагүй байсныг залруулав.
- Соёлын төвийн санхүүгийн тайлангийн уялдаа холбоог шалгахад Санхүүгийн үр дүн мөнгөн гүйлгээ 0.2 сая төгрөгөөр зөрснийг, БСШЯ-аас ирсэн 13.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1.1 сая төгрөгийн бараа материалыг хандив тусламж ангилалд бүртгэснийг тус тус залруулав.
- ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн дансдын уялдааг шалгах явцад нийт 4.7 сая төгрөгийн данс бүртгэлийн алдааг залруулав.
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан 114.6 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагад олгох дутуу санхүүжилт болох 63.4 сая төгрөгийг өглөгөөр бүртгээгүй, 81.4 сая төгрөгийн барилгын ажлын гүйцэтгэлийг хөрөнгийн дансанд бүртгээгүй байсныг залруулав.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 88.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 70.7 сая төгрөг болж 17.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	88.3	70.7	17.6	19.9
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	88.3	70.7	17.6	19.9

Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ОНХС-ийн 26.8 сая төгрөг, СХС-ийн 17.7 сая төгрөг, НСС-ийн 13.9 сая төгрөг, нэмэлт дансны санхүүжилтийн үлдэгдэл 2.2 сая төгрөг, ЗДТГ-ын ахмадын сангийн 1.1 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн ахмадын сангийн 5.4 сая төгрөг, соёлын төвийн ахмадын сангийн 1.2 сая төгрөг, эрүүл мэндийн төвийн ахмадын сангийн 1.6 сая төгрөг, цэцэрлэгийн ахмадын сангийн 0.8 сая төгрөгийн үлдэгдэл тус тус тайлагнагдсан байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 76.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 204.0 сая төгрөг болж, 127.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Байгууллагаас авах авлага	174.8	239.7	64.9
Зээлийн авлага			
Дүн	174.8	239.7	64.9

Эх сурвалж: Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын 94 хувь нь сум хөгжүүлэх сангийн авлага байгаа ба дүнд эзлэх хувиар 3-аас жилийн насжилттай авлага 62 хувийг эзэлж байна.

2.8.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 233.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 283.9 сая төгрөг болж, 50.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+/ бууралт/-/
БАРАА МАТЕРИАЛ	233.3	283.9	50.6
Түүхий эд материал	36.7	49.9	13.2
Тусгай зориулалттай материал	32.7	34.7	2.0
Эм боох материал	4.0	15.2	11.2
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0	0
Хангамжийн материал	137.9	174.8	36.9
Бичиг хэргийн материал	2.5	3.1	0.6
Аж ахуйн материал	123.5	157.8	34.3
Сэлбэг хэрэгсэл	0.3	0.3	0.0
Түлш, шатах тослох материал	1.5	2.1	0.6
Барилгын засварын материал	0.7	0.7	0.0
Хүнсний материал	6.4	6.9	0.5
Бусад хангамжийн материал	3.0	3.9	0.9
Биологийн хөрөнгө	0	0	0
Мал амьтад	58.7	59.2	0.5

Эх сурвалж: Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4482.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4466.3 сая төгрөг болж, 104.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4362.2	4466.3	104.1
Барилга, байгууламж, орон сууц	3585.8	3609.8	24
Авто-тээврийн хэрэгсэл	345.7	409.8	64.1
Хуримтлагдсан элэгдэл	-257.9	-292.7	-34.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	292.9	344.4	51.5
Хуримтлагдсан элэгдэл	-190.9	-230.4	-39.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	186.2	204.4	18.2
Бусад үндсэн хөрөнгө	909	1043.5	134.5
Дуусаагүй барилга, байгууламж		81.4	81.4
Ном	19.6	19.9	0.3
Биет бус хөрөнгө	120.3	120.7	0.4
Програм хангамж	4.3	4.9	0.6
Бусад биет бус хөрөнгө	120	120	0

Эх сурвалж: Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 32.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 72.8 сая төгрөг болж, 40.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Өглөг	32.3	72.8	40.5	125
Ажилчидтай холбоотой өглөг	0.6	0.2	-0.4	(67)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.3	6.7	6.4	2,133
Байгууллагад төлөх өглөг	30.8	65.8	35	114
Хувь хүмүүст төлөх өглөг	0.6	0.1	-0.5	(83)

Эх сурвалж: Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр өссөн нь богино хугацаат өр төлбөр байна.

Илрүүлэлт: Засаг даргын тамгын газар түлш халаалтын зардлын 3.3 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4946.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5108.5 сая төгрөг болж, 162.0 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2574.6	2574.6	-	0
Хуримтлагдсан үр дүн	919.6	1081.6	162.0	17.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1452.3	1452.3	0	0
Дүн	4946.5	5108.5	162.0	3.3

Эх сурвалж: Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Өргөн сумын ИТХ-ын 2019 оны 12 сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 8/04 дугаар тогтоолоор тайлант онд 66.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 119.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 77.9 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	3.9	2.1	(1.8)	54.5
2	Хадгаламжийн хүүгийн орлого	8.2	12.9	4.6	155.8
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	8.8	15.8	7.0	178.7
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	2.2	0.6	(1.6)	27.3
5	Бууны албан татвар	1.9	1.6	(0.3)	84.7
6	Улсын тэмдэгтийн хураамж	1.4	16.8	15.4	1,191.5
7	Ан агнах зөвшөөрлийн хураамж	27.0	59.6	32.7	221.2
8	Хог хаягдлын хураамж	8.3	2.8	(5.5)	33.6
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.1	-	(0.1)	-
10	Хүү торгуулийн орлого	0.1	1.4	1.3	1,400.0
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5.0	5.5	0.5	110.0
Дүн		66.9	119.1	52.1	177.9

Төсвийн орлого нийт дүндээ 52.1 сая төгрөгөөр давсан байна.

Орлогын төлөвлөгөө давсан нь дараах шалтгаантай байна.

- Хадгаламжийн хүүгийн орлого тайлант онд банкны тооцоолсон хүү батлагдсан төсөв, нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор төлөвлөснөөс 4.6 сая төгрөгөөр;
- Хувь хүний орлогын албан татвар нь иргэдийн худалдан авалт төлөвлөснөөс их байсантай холбоотойгоор 7.0 сая төгрөгөөр;
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого болон ан агнах зөвшөөрлийн хураамж БОЯ-аас 1 аргаль нэмж агнах зөвшөөрөл олгосноор 48.1 сая төгрөгөөр;
- Хүү торгуулийн орлого сумын цагдаагийн хэсэг торгуулийн машинтай болсноор 0.5 сая төгрөгөөр;
- Төсөвт байгууллагын өөрийн орлого соёлын төвийн үйл ажиллагаатай холбоотой 0.5 сая төгрөгөөр давуулан биелсэнтэй холбоотой байна.

Орлогын төлөвлөгөө тасарсан нь дараах шалтгаантай байна.

- Үйл ажиллагааны орлого болон хөрөнгө борлуулсны орлого нь тайлант онд 3.4 сая төгрөгөөр;

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого нь тус суманд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлодог Бишрэлт түшиг ХХК үйл ажиллагаа явуулаагүйгээс орлого бүрдээгүй шалтгаантай байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 29 хөтөлбөрт зориулан 1800.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 256.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1543.9 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1053.2 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 633.7 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 20.3 сая төгрөгийг сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос 93.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1018.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 629.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 17.0 сая төгрөгийг нийт 1688.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 18.3 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 4.9 сая төгрөг бүрдүүлсэн байна. Мөн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнд сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн сангийн дансны үлдэгдлийн дүнгээр дараа онд санхүүжих дүнг төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд сумын ОНХС-ийн хөрөнгөөр шинээр 7 ТАХ-г тайлант онд 182.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор, он дамжиж ирсэн 1 ТАХ-д 27.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр шинээр хэрэгжсэн ажилд 155.8 сая төгрөгийн, он дамжиж ирсэн ТАХ-д 23.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 38.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12.8 сая төгрөг, нийт 51.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, зарцуулсан байна.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 47.0 сая төгрөг, 1.9 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 2.2 сая төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар байгууллагуудын ахмадын сангийн санхүүгийн үйл ажиллагааг авч үзэх.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 62 мэдээллийг байршуулахаас 40 хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 15 огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, сангуудын залруулагдаагүй зөрчлийн дүнг нэгтгэн үзэхэд 8.1 сая төгрөг байх бөгөөд нийт

залруулаагүй алдаа зөрчлийг 8.1 сая төгрөгөөр тооцож бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байх тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	496,313,303.49	594,426,647.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,258,771.00	70,766,451.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	88,258,771.00	70,766,451.00
31210	Төгрөг	88,258,771.00	70,766,451.00
31211	Төрийн сангийн харилцах	88,258,771.00	70,766,451.00
33	АВЛАГА	174,750,447.00	239,689,460.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	203,159.00	200,000.00
33500	Бусад авлага	54,186,660.00	73,738,205.92
33510	Байгууллагаас авах авлага	51,549,297.00	66,737,608.92
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,637,363.00	7,000,597.00
33600	Зээлийн авлага	120,360,628.00	165,751,255.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	120,360,628.00	165,751,255.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	120,360,628.00	165,751,255.00
35	БАРАА МАТЕРИАЛ	233,304,085.49	283,970,735.45
35100	Түүхий эд материал	36,713,286.72	49,933,607.68
35110	Тусгай зориулалттай материал	32,749,477.56	34,738,977.56
35130	Эм боох материал	3,963,809.16	15,194,630.12
35400	Хангамжийн материал	137,852,758.77	174,754,087.77
35410	Бичиг хэргийн материал	2,484,304.00	3,084,620.00
35420	Аж ахуйн материал	123,533,568.77	157,837,820.77
35430	Сэлбэг хэрэгсэл	339,900.00	294,900.00
35440	Түлш, шатах тослох материал	1,425,600.00	2,113,924.00
35450	Барилгын засварын материал	655,120.00	655,120.00
35460	Хүнсний материал	6,436,279.00	6,893,616.00
35470	Бусад хангамжийн материал	2,977,987.00	3,874,087.00
35600	Мал амьтад	58,738,040.00	59,283,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,482,534,928.70	4,586,948,572.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,482,534,928.70	4,586,948,572.74
39200	Биет хөрөнгө	4,362,221,470.57	4,466,259,926.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,585,782,126.00	3,609,776,626.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,422,371.32	-158,320,904.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	345,670,543.00	409,840,543.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-257,963,801.69	-292,748,100.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	292,982,895.29	344,452,220.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,968,012.83	-230,412,927.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	186,243,404.35	204,362,634.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-111,947,561.05	-127,932,844.33
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	8,005.69	8,005.69
39212	Хуримтлагдсан элэгдэл	-8,005.69	-8,005.69
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,044,000.00	8,044,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	909,003,618.13	1,043,455,136.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,803,495.83	-445,594,717.79
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	81,438,935.00
39217	Ном	19,600,126.52	19,899,326.52
39300	Биет бус хөрөнгө	120,313,458.13	120,688,645.88
39301	Програм хангамж	4,256,000.00	4,861,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,990,541.87	-4,220,354.12
39303	Бусад биет бус хөрөнгө	120,048,000.00	120,048,000.00

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,978,848,232.19	5,181,375,220.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,306,918.29	72,836,958.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,306,918.29	72,836,958.10
41300	Өглөг	32,306,918.29	72,836,958.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	654,572.29	190,163.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	264,535.00	6,731,229.90
41360	Бусад өглөг	31,387,811.00	65,915,565.00
41361	Байгууллагад төлөх өглөг	30,819,421.00	65,766,465.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	568,390.00	149,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,946,541,313.90	5,108,538,262.01
51	Засгийн газрын хувь оролцоо	4,946,541,313.90	5,108,538,262.01
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,574,622,745.98	2,574,622,745.98
51200	Хуримтлагдсан үр дүн	919,583,904.32	1,081,580,852.43
51210	Өмнөх үеийн үр дүн	983,168,794.54	917,058,017.32
51220	Тайлант үеийн үр дүн	-63,584,890.22	164,522,835.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,452,334,663.60	1,452,334,663.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,978,848,232.19	5,181,375,220.11

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,980,950,724.32	2,593,845,340.33
11	ТАТВАРЫН ОРЛОГО	326,297,131.03	99,409,248.95
110	Орлогын албан татвар	25,380,231.03	18,480,398.95
1100	Хувь хүний орлогын албан татвар	25,380,231.03	18,480,398.95
110002	Үйл ажиллагааны орлого	9,135,534.00	2,065,550.00
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,895,096.00	646,600.00
110008	Шууд бус орлого	13,349,601.03	15,768,248.95
113	Хөрөнгийн албан татвар	1,862,000.00	1,638,000.00
113002	Бууны албан татвар	1,862,000.00	1,638,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	299,054,900.00	79,290,850.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	271,539,860.00	19,644,130.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,593,860.00	16,806,130.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	265,300,000.00	0.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,646,000.00	2,838,000.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,515,040.00	59,646,720.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	27,515,040.00	59,646,720.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	296,310,016.85	279,117,688.41
120	Нийтлэг татварын бус орлого	296,310,016.85	279,117,688.41
120002	Хүүгийн орлого	12,444,032.53	13,867,868.72
120003	Торгуулийн орлого	50,000.00	1,395,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	282,890,748.32	263,854,819.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,501,400.00	3,779,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,613,811.00	13,444,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	269,775,537.32	246,631,519.69
120009	Бусад орлого	925,236.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,358,343,576.44	2,215,318,402.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	989,815,664.00	1,086,904,620.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	969,815,600.00	843,016,700.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	20,000,064.00	243,887,920.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,073,247.00	48,806,054.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,481,447.00	38,247,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	591,800.00	10,558,337.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	352,454,665.44	1,062,590,048.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,574,800.00	643,486,600.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	5,239,864.78	5,888,148.97

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	5,640,000.66	413,215,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	17,017,680.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	17,017,680.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,847,593,284.27	2,429,272,505.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,847,593,284.27	2,383,383,919.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,432,918,104.97	1,812,777,055.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,056,910.48	913,629,332.98
210101	Үндсэн цалин	672,308,426.81	797,986,883.29
210102	Нэмэгдэл	48,457,011.67	70,063,716.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	915,500.00
210104	Урамшуулал	32,291,472.00	44,663,233.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,201,343.27	112,946,073.85
210201	Тэтгэврийн даатгал	62,730,732.95	75,761,066.96
210202	Тэтгэмжийн даатгал	7,141,757.13	8,326,784.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,641,194.10	8,553,251.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,048,384.16	1,917,895.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,639,274.93	18,387,075.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,032,479.00	189,869,872.39
210301	Гэрэл, цахилгаан	14,437,862.00	16,713,383.49
210302	Түлш, халаалт	155,901,301.00	162,758,421.90
210303	Цэвэр, бохир ус	7,693,316.00	10,398,067.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,293,378.40	229,819,235.60
210401	Бичиг хэрэг	13,460,854.00	15,790,835.00
210402	Тээвэр, шатахуун	28,739,108.00	35,959,796.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,343,525.00	3,708,110.00
210404	Ном, хэвлэл	54,500.00	16,000.00
